



Н.Гэндэнжамцын нэрэмжит Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт Нэгдсэн үндэстний байгууллагын шагналт **ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ**

ЭХЭМҮТ-ИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, ЧИГ ҮҮРЭГ



ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Монгол улс



Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв нь үндэсний хэмжээнд эх, хүүхдэд эмнэлгийн төрөлжсөн мэргэжлийн тусламжийг чанарын өндөр түвшинд хүргэхээр зорин тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулан, эмчилгээ, оношилгоондоо орчин үеийн шинэ, техник технологийг нэвтрүүлэх, нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт зорилтот бүлгийн хүн амыг хамруулах, төвлөрлийг сааруулах, гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлдэг өвчний тоог бууруулах, эмч, шинэ дэвшилтэт технологийг эзэмшин, нутагшуулж **төрөлжсөн мэргэжлийн 28 тасаг; 2 зөвлөх поликлиник;** өсвөр үеийн клиник, үргүйдэл - нөхөн үржихүйн төв, 11 албатайгаар эх, эмэгтэйчүүд, ураг-нярай, хүүхдэд төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлж, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч, үндэсний хэмжээнд үйлчилгээ үзүүлдэг лавлагаа төв байна.

БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХҮНИЙ НӨӨЦ

ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ ОР
680

ХҮҮХДИЙН ЭМНЭЛЭГ-424 ОР

- Дотрын ор-273
- Мэс заслын ор-151
- Төрөлхсөн тасаг-23
- ХЭП
- Өсвөр үеийн клиник
- Нүдний шилний кабинет
- Зайн анагаахын хэсэг

ЭХ БАРИХ,
ЭМЭГТЭЙНҮҮДИЙН
ЭМНЭЛЭГ-256 ОР

- 12 Төрөлхсөн тасаг
- НҮЭП
- Үргүйдэл нөхөн үржихүйн төв
- Зайн анагаахын хэсэг

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
САЛБАР

- ЭШ-ийг секторууд, Тандалт судалгааны алба, АУЭП,
- ССА: Хүүхэд, Эх барих, Сувилахуйн тэнхим, НЭМН
- Статистик мэдээлэлзүй
- Мэдээллийн технологи
- Зайн анагаахын хэсэг

Дэмжих үйлчилгээ (17 тасаг, алба)



ЭМЧ, ЭМНЭЛГИЙН АЖИЛТАН-1209

- Их эмч-266 Рецидент эмч-59
- Сувилагч, тусгай мэргэжилтэн-452
- Бусад ажилтан-302

- Ардын эмч-3
- Төрийн соёрхолт-11
- Хүний гавьяат эмч-31
- ЭХГ аймагт ажилтан-2
- АШУ-ы доктор-7
- АУ-ны доктор-96

Эмч нарын мэргэжлийн зэрэг-60% (139)

- Зөвлөх 14.7% (36)
- Тэргүүлж- 22% (54)
- Ахлах 21% (52)

Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн зэрэг- 52% (234)

- Зөвлөх 1.3% (6)
- Тэргүүлж- 18% (84)
- Ахлах 32% (144)

ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ

ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ НЬ УЛС ОРНЫ ХӨГЖИЛ, ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТҮВШИНГ ИЛТГЭДЭГ.



ДЭЛХИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ – 2030

✓ Дэлхий нийтийн тогтвортой хөгжилд хүрэх урт хугацааны бодлогын баримт бичгийг (ТХЗ 2030) 2016 оны 1 дүгээр сарын 1-нээс албан ёсоор дэлхий нийтээр хэрэгжүүлж эхэлсэн.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН 3.1-д 2030 ОНД

➢ Эхийн эндэгдлийн харьцааг (100 000 амьд төрөлтөд) 70 ба түүнээс доош болгож бууруулах.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН 3.2-т 2030 ОНД

➢ Нялхас, 5 хүртэлх насны хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг тэглэх
➢ Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 25-аас доош болгон бууруулах
➢ Нярайн эндэгдлийн түвшинг 12-оос доош болгон бууруулах зорилт тавьсан.

✓ Дэлхийн Тогтвортой Хөгжлийн зорилт (ТХЗ)-ыг улс орон бүр өөрийн онцлогт нийцүүлэн хэрэгжүүлэх талаар ихээхэн чармайлт тавин ажиллаж байна.



Н.Говьсүмбэр-Очирагч

МОНГОЛ УЛСАД БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО

“АЛСЫН ХАРАА 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого нь 9 зорилго, 47 зорилттой, зорилт тус бүрийн хүрэх үр дүнг 2021-2030 он, 2031-2040 он, 2041-2050 он гэсэн 3 үе шаттайгаар тодорхойлсон байдаг.



АЛСЫН ХАРАА 2050 МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

ҮЗҮҮЛЭЛТ	ХҮРЭХ ЗОРИЛТ		
	I ҮЕ ШАТ 2025	II ҮЕ ШАТ 2030	III ҮЕ ШАТ 2050
Сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин буурсан байна.			
1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин (промил)	9	8	2.3
100000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн харьцаа (просантимил)	20	15	5

Утас: 362633, 362205
E-mail: ehemut@moh.com
Вэб сайт: www.ehemut.mn



Н.Говьсүмбэр-Очирагч
ЭХ ХҮҮХДИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

ДЭЛХИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД ХҮРЭХИЙН ТУЛД ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ, МОНГОЛ УЛС



Утас: 362633, 362205
E-mail: ehemut@moh.com
Вэб сайт: www.ehemut.mn



ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, ДЭЛХИЙ ДАХИНД

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл нь аливаа улс орны эрүүл мэнд, хүн амын сайн сайхан аж байдлын чухал үзүүлэлт хэмээн тооцогддог. Дэлхийн **ТХЗ-д 2030 онд бүх улс орнууд**

- ✓ Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн **сэргийлж болох эндэгдлийг тэглэх**
- ✓ Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг **25-аас доош болгон бууруулах**
- ✓ Нярайн эндэгдлийн түвшинг **12-оос доош болгон бууруулах** зорилт тавьсан.

Дэлхий дахинд 1990 оноос хойш тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулахад ихээхэн амжилт гаргасан.

ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, НИЯРАЙН ЭНДЭГДЭЛ, ДЭЛХИЙ ДАХИНД, 1990 ОН, 2023 ОН

СОНГОСОН ҮЗҮҮЛЭЛТ	1990	2023
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд)	93	44.6
Нярайн эндэгдлийн түвшин	36.6	17.5
Тав хүртэлх насанд эндсэн хүүхдийн тоо	12.6 сая	4.8 сая

Дэлхийн ТХЗ-д хүрснээр тав хүртэлх насны 11 сая хүүхэд эндэхээс урьдчилан сэргийлэх боломжтой болно хэмээн тооцоолсон.



ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, ДЭЛХИЙ ДАХИНД

Дэлхийн **тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 47.0%-ийг нярайн эндэгдэл** эзэлж байна. **Нярайн эндэгдлийн зонхилох шалтгаанд** дутуу төрөлтийн хүндрэл, төрөлхийн хөгжлийн гажиг, төрөх үеийн хүндрэл, амьсгалын замын цочмог халдвар, үжил орж байна. **29 хоногоос тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаанд** амьсгалын замын цочмог халдвар, хумхаа, суулгалт өвчин зонхилж байна.

ТХЗ-д хүрэхийн тулд эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх, тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлэх, нийгмийн үндсэн хүчин зүйлсийг шийдвэрлэхэд тасралтгүй хүчин чармайлт гаргах нь чухал. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэлд нөлөөлж байгаа гол хүчин зүйлс нь улс орны нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс (ядуурал, эхийн боловсрол, хоол тэжээл, алслагдсан байдал), эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанартай үйлчилгээ авах зэрэг арга хэмжээг оновчтой зохион байгуулаагүй, дархлаажуулалт хангалтгүй байх зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна.

* Эх үүсвэр: WHO, UNFPA, UNICEF, World Bank Group, UNDESA/Population Division, 2025

СЭРГИЙЛЖ БОЛОХ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙГ БУУРУУЛАХЫН ТУЛД:

- ✓ Хүүхдийг хөхөөр дагнан хооллох;
- ✓ Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн тусламж үйлчилгээг мэргэшсэн, чадвартай эрүүл мэндийн ажилтнууд үзүүлэх;
- ✓ Хоол, бичил тэжээлийн хангамж, хүртээмжийг сайжруулах;
- ✓ Иргадад хүүхдийн өвчний үед илрэх аюултай шинжийн талаар эрүүл мэндийн боловсрол олгох;
- ✓ Ус, ариун цэвэр, эрүүл ахуйг сайжруулах, дархлаажуулалтад хамруулах.